

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

№ 19 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/19

Сүмбэр сум

“Яргуйхан-2019” урлагийн наадамд
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит “Яргуйхан-2019” урлагийн наадмыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит хүүхдийн урлагийн “Яргуйхан-2019” урлагийн наадам зохион байгуулахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн /Э.Урантунгалаг/-д даалгасугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 1 019 000 /нэг сая арван есөн мянган/ төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

421190031